



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 16 өдөр

Дугаар 489

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон, нийт 489,873,493.40 (дөрвөн зуун наян есөн сая найман зуун далан гурван мянга дөрвөн зуун ерэн гурван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 30 автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, хурандаа Б.Нандинболор болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Орон нутгийн өмчийн газраас төлөөлөгч оролцуулан дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны дугаар сарын 8-ны өдрийн
489 ... дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗАР, ТҮҮНИЙ ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД,
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Д/д	Автомашинны нэр, марк	Ашиглал тад орсон, дахин үнэлсэн он	Хэм нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1. Увс аймаг дахь ШШГГ								
1	1	Фургон УАЗ220695, 44-59 УВА	2016	ш	1	8,137,500.00	8,137,500.00	1,000,000.00
		Дүн			1		8,137,500.00	1,000,000.00
2. Банкны өр барагдуулах газар								
2	1	Приус-20, 85-10 УБХ	2016	ш	1	12,000,000.00	12,000,000.00	1,800,000.00
3	2	Карнивал киа, 01-61 УНВ	2021	ш	1	17,500,000.00	17,500,000.00	1,000,000.00
		Дүн			2		29,500,000.00	2,800,000.00
3. Хэнтий аймаг дахь ШШГГазар-419 дүгээр нээлттэй хорих анги								
4	1	Фургон, 00-39 ХЭҮ	2021	ш	1	9,300,000.00	9,300,000.00	1,500,000.00
5	2	Фургон, 88-39 ХЭҮ	2021	ш	1	5,624,640.00	5,624,640.00	1,400,000.00
		дүн			2		14,924,640.00	2,900,000.00
4. 407 дугаар нээлттэй, хаалттай хорих анги								
6	1	Ландкрудер-80, 04-07 УНО	2009	ш	1	20,000,000.00	20,000,000.00	2,000,000.00

[illegible]

Д/д	Д/д	Автомашинны нэр, марк	Ашиглал тад орсон, дахин үнэлсэн он	Хэм нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
19	1	Фургон УАЗ-220695, 00-45 БНХ	2015	ш	1	31,000,000.00	31,000,000.00	2,500,000.00
		Дүн			1		31,000,000.00	2,500,000.00
10. 405 дугаар хаалттай хорих анги								
20	1	Фургон, 64-05 УБҮ	2014	ш	1	31,000,000.00	31,000,000.00	2,500,000.00
21	3	Лексус-470, 40-51 УБО	2022	ш	1	833,333.40	833,333.40	7,000,000.00
		Дүн			2		31,833,333.40	9,500,000.00
11. "Хэрэмт цамхаг" УТҮГ- үйлдвэр								
22	1	Ландкрейсер-80, 41-43 УНТ	2012	ш	1	35,000,000.00	35,000,000.00	2,000,000.00
23	2	Киа пронтер, 53-75 УБЧ	2009	ш	1	4,700,000.00	4,700,000.00	900,000.00
		Дүн			2		39,700,000.00	2,900,000.00
12. "Хэрэмт цамхаг" УТҮГ- төсөв								
24	1	Маз кран, 77-94 УББ	2011	ш	1	3,000,000.00	3,000,000.00	2,500,000.00
25	2	Зил 130, ам-22 өргөгч, крантай 45-56 УБХ	2013	ш	1	29,000,000.00	29,000,000.00	2,700,000.00
26	3	Ачигч трактор /жижиг/	2007	ш	1	10,839,720.00	10,839,720.00	1,500,000.00
		Дүн			3		42,839,720.00	6,700,000.00
13. Булган аймаг дахь ШШГГ								
27	1	Старекс, 00-20 БУЛ	2013	ш	1	25,000,000.00	25,000,000.00	2,000,000.00
28	2	Маяти, 45-13 УБЕ	2012	ш	1	17,500,000.00	17,500,000.00	1,800,000.00
		Дүн			2		42,500,000.00	3,800,000.00
14. Говь-Алтай аймаг дахь ШШГГ								
29	1	Тоёота приус-20, 22-67 ГАА	2017	ш	1	12,000,000.00	12,000,000.00	2,000,000.00
30	2	Уаз фургон, 71-81 ГАА	2018	ш	1	33,000,000.00	33,000,000.00	1,500,000.00
		Дүн			2		45,000,000.00	3,500,000.00

Д/д	Д/д	Автомашины нэр, марк	Ашиглал тад орсон, дахин үнэлсэн он	Хэм нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
30		НИЙТ ДҮН					489,873,493.40 (дөрвөн зуун наян есөн сая найман зуун далан гурван мянга дөрвөн зуун ерэн гурван төгрөг дөчин мөнгө)	54,300,000.00 (тавин дөрвөн сая гурван зуун мянга)